



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 5/59

Улаанбаатар хот

Мөнгөн шагнал олгох тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8, 9.6.10 дахь заалт Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Онц түвэгтэй даалгаврыг биелүүлж, төрд учирч болох 7.9 тэрбум төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлж, хууль, хяналт шүүхийн байгууллагад Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг амжилттай хамгаалахад мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж, удирдан зохион байгуулсан Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэд нэг сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн шагнал, тус яамыг төлөөлөн шүүх хуралдаанд оролцож, мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж ажилласан Хуулийн хэлтсийн ахлах шинжээч С.Мяндасмаа, мэргэжилтэн Б.Цэнд, Д.Оюунсүрэн нарт нэг сарын үндсэн цалингийн 50.0 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг тус тус олгосугай.

2.Мөнгөн шагналд олгогдох зардлыг зохих зардлаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



С.БАТБОЛД

080000403